

## ЭХЛЭЛ

Анхны дугаар 2011.09

Гарчиг

 Project E-News

**[Монгол Япон хоёр улсын найрамдлын бэлгэ тэмдэг болсон “Нарны гүүр”**


Төсөл хариуцсан ажилтан Э. Анхцэцэг

 Volunteer E-News

**[ЖАЙКА-ийн сайн дурынхан**

Сайн дурынхныг хариуцсан ажилтан

Ц. Орхонтуяа

 Сургалт төгсөгчдийн булан

Сургалт төгсөгч Ё. Баярхүү

 Төлөөлөгчийн газрын үйл явдал

 Хүний нөөцийг хөгжүүлэх төсөл

**2012-2013 оны тэтгэлэгт хөтөлбөрийн бүртгэл эхэллээ ! [Цааши унших](#)**

Бэлтгэсэн :

Сургалт хариуцсан ажилтан

Х. Түвшин-Од

**Жайка Монгол дахь төлөөлөгчийн газар**

Бодь цамхаг 7 давхар,

Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар

УТАС: 976-11-325939, 312393

ФАКС: 976-11-310845

E-mail: [mg\\_oso\\_rep@jica.go.jp](mailto:mg_oso_rep@jica.go.jp)

<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

Зүүн хойд нутагт болсон газар хөдлөлтөөр асар их хохирол амссан Япон улс өнөөдөр сэргээн босголт руу чиглэн эрч хүчтэй алхаж байна. Газар хөдлөлтийн дараа Улаанбаатар хотод ЖАЙКА-ийн хамтран ажилладаг байгуулага, хувь хүмүүсийн зүгээс халуун сэтгэлийн тусламжийн аян өрнөсөн билээ. Сургалт төгсөгчдийн холбоо болон 2009 онд сургалтанд хамрагдсан хэсэг төгсөгчид манай төлөөлөгчийн газарт хандан эмгэнэлээ илэрхийлэхийн зэрэгцээ хандивийн мөнгөн тусламж үзүүлсэн. Мөн Батболд ерөнхий сайд яг газар хөдөлсний дараа буюу 3 сарын 11-ний өдрийн 15 цаг 15 минутанд ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдтэй хийж байсан уулзалтын үеэр газар хөдлөлт болсонд гүнээ эмгэнэж байгаагаа хамгийн түрүүнд илэрхийлсэн юм. Энэ завшааныг ашиглан Батболд ерөнхий сайд болон Монголын ард түмнээс ирүүлсэн халуун сэтгэлийн тусламжинд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа дахин илэрхийлье.

Ингээд сургалт төгсөгч та бүхэнд нэгэн мэдээ хүргэхэд, 2011 оны 9 сараас эхлэн ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар та бүхэнд зориулан цахим сонинг эрхлэн гаргаж байхаар боллоо. ЖАЙКА-тай холбоотой мэдээ болон үйл ажиллагааны мэдээлэлийг уг сониноороо дамжуулан 2 сард 1 удаа хүргэнэ. Сонин маань ЖАЙКА-ийн төсөл хөтөлбөр (Project E-news), сайн дурын гишүүдийн үйл ажиллагаа (Volunteer E-news) зэрэг Монгол дахь үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллээр хангана. Мөн сургалт төгсөгчдийн эх орондоо буцаж ирээд явуулж буй үйл ажиллагаа, өдөр тутмын ажлын талаар дамжуулах булан байх ба энэ нь сонингийн маань салшгүй нэгэн хэсэг болно.

PDF хэлбэрийн сонинг тус төлөөлөгчийн газрын вебсайтад байрлуулахаас гадна шуурхай байлгахын тулд цахим шуудангаар давхар хүргэх бөгөөд та бүхнээс нийтлэлийн агуулга, хэлбэр дизайны тухай санал сэтгэгдэлийг дуртайяа хүлээн авах болно. Сургалт төгсөгчидтэйгээ хамт алхах сонингийн хувьд та бүхэнд ойр дотно байж, ажил үйлс тань улам бүр дэвжин дээшилж, улмаар Монгол улс маань хөгжин цэцэглэхэд хувь нэмэр болж чадвал бид бүхэн баяртай байх болно.

## ***【Монгол Япон хоёр улсын найрамдлын бэлгэ тэмдэг болсон “Нарны гүүр”】***

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын автомашины тоо эрс нэмэгдснээр замын хөдөлгөөний ачаалал ихэсч, замын түгжрэл нийслэлийн томоохон асуудлын нэг болоод байна. Төмөр замаар тусгаарлагдсан хотын өмнөд хэсгийн үйлдвэрийн район болон хотын төвийг холбосон гүүрүүд элэгдэж хуучран ачааллаа дийлэхээ больж, улмаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад ч бэрхшээлтэй болж байна.

Иймд Япон улсын Засгийн газрын 3.7 тэрбум иен буюу 50 орчим тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар Улаанбаатар төмөр зам дээгүүрх гүүрэн гарц барих төслийг хэрэгжүүлэхээр болсон юм. Гүүрийн нийт урт дөхөх замтай нийлээд 895м бөгөөд Монгол улсад анх удаа нэвтрүүлж буй ган хийцтэй төмөр бетон гүүр юм. Энэ гүүр ашиглалтанд орсноор Баруун 4 замаас урагш Цагаан хаалга хүртэлх 4.7км зам 1.8км болон богиносч, хотын баруун хэсгээс Нисэх хүртэл чөлөөтэй зорчих боломжтой болж, замын түгжрэл ч багасна.

Хүйтний улирал удаан үргэлжилдэг манай улсад зам барилгын ажил гүйцэтгэх хугацаа маш богино байдаг.

Энэ бэрхшээлийг давахын тулд уг гүүрийг барих явцад бетон цуггалт, хучилтын ажлыг битүү байранд 5-аас 10-р сарын хооронд гүйцэтгэх, гүүрний эд ангийн бетон эд ангийг урьдчилан захиалж хийлгэх зэргээр өвөл зуны ажлын төлөвлөгөөг нарийн гаргаж, өндөр зохион байгуулалттай ажиллаж ирсэн.

2011 оны 5-р сард Улаанбаатар хотод дизель шатахууны хомсдол үүссэн үед гүүрний барилгын ажил зогсож болзошгүй байсан хэдий ч Монгол талын төсөл хэрэгжүүлэгчдийн хүчин чармайлтын үр дүнд ямар нэг саадгүй үргэлжилсэн юм.

Улаанбаатарчуудын сайн мэдэх “Нарны зам” Япон улсын буцалтгүй тусламжаар 2003 онд баригдсан бөгөөд шинээр баригдаж буй гүүрийг ч Наран улсын бэлгэ тэмдэг болсон Нарны гэсэн нэрээр тодотгон нэрлэсэн юм. Нарны гүүр маань 2012 оны 11-р сард ашиглалтад орох бөгөөд хойшид хоёр улсын найрамдлын бэлгэ тэмдэг болох нь дамжиггүй.



**Гүүрний барилгын ажлын байдал**



**Гүүрний баригдаж дууссаны дараах төлөвлөгөөт зураг**

## 【ЖАЙКА-ийн сайн дурынхан】



### Монгол улсын Ерөнхий сайдтай хийсэн уулзалт

2011 он 3 сар

ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн илгээх үйл ажиллагаа 1965 оноос эхэлж, өнөөг хүртэл дэлхийн 87 оронд нийт 35,000 гаруй сайн дурын гишүүдийг илгээгээд байна. Сайн дурынхан гэдэг нь томилогдсон орныхоо ард түмэнтэй мөр зэрэгцэн ажиллаж амьдарснаар сайн дурын гишүүдийн мэдлэг чадвар болон Японы техник технологийн ололттой талыг хөгжиж буй орнуудын бүтээн байгуулалт, хүний нөөцийг хөгжүүлэх зорилготой “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрэн дэхь үйл ажиллагаа юм.

Сайн дурын гишүүдийг насаар нь залуу (20-39 нас) ба ахмад (40-69 нас) гэж ангилдаг. Мөн томилогдох хугацаа нь урт хугацааны (1-2 жил) болон богино хугацааны (1-10 сар) гэсэн төрөлтэй. Мөн хамтын ажиллагааны хамрах хүрээ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, электроник, барилга, эрүүл мэнд, боловсрол, спорт зэрэг олон салбарыг хамардаг. Японд жилд 2 удаа сонгон шалгаруулалт явуулж тэнцсэн хүмүүс нь улиралд 1 удаа томилогдон ирдэг. Тэнцсэн хүмүүс ирэхээс өмнө болон ирснийхээ дараа монгол хэлний сургалтанд хамрагддаг.

Монгол улсад 1991 оны 4 сараас эхлэн ЖАЙКА-ийн сайн дурынханыг томилж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл нийт 400 гаруй гишүүд олон төрлийн мэргэжлээр томилогдон ажиллаад байна. 2004 онд Япон улсын засгийн газраас Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрт үндэслэн “Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог сайжруулах боловсон хүчин бэлтгэхэд туслах”, “Хөдөө орон нутгийг хөгжүүлэх”, “Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж”, “Эдийн засгийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн хөгжил” зэрэг чиглэлээр цэцэрлэгийн багш, бага ангийн багш, математикийн багш, байгаль шинэжлэлийн багш, япон хэлний багш, компьютерийн мэргэжилтэн, барилгын мэргэжилтэн, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, согог зүйч, хөдөлгөөн засалч, ахуйн засалч, хэл засалч, орон нутгийн хөгжлийн ажилтан, өсвөр

үеийнхэний хөгжлийн ажилтан, хог хаягдал боловсруулалт, байгаль орчны боловсрол, аялал жуулчлал, хот төлөвлөлт, спорт, цахилгаан станцийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг мэргэжлээр сайн дурын гишүүд томилогдон ажиллаж байна. Анх Улаанбаатар хотоос гараагаа эхэлсэн сайн дурынханы үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд хөдөө орон нутаг руу чиглэх болсноор Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Говьсүмбэр зэрэг аймагт хамтын ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид Төв, Дорноговь зэрэг аймгуудтай хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна. Одоогийн байдлаар Монгол улсад нийт 76 сайн дурын гишүүн ажиллаж байгаагаас 25 нь ахмад, 51 нь залуу сайн дурын гишүүн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол дахь сайн дурын гишүүдийн үйл ажиллагаа улам бүр өргөжиж, Монгол улсын засгийн газрын хүрээнд хөхүүлэн дэмжиж буй бөгөөд сүүлийн 2 жил Монгол улсын ерөнхий сайд С.Батболд сайн дурын гишүүдийг хүлээн авч уулзан тэдний үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал зэргийн тухай санал бодлоо солилцдог болсон нь бидний үйл ажиллагааг төр засгаас дэмжиж буйн илрэл юм.

Тун удахгүй 9-р сарын 26-нд монгол орны хөгжил цэцэглэлтэнд өөрийн хувь нэмрээ оруулахаар тус бүрийн хүсэлт гаргасан доорхи байгууллагуудад нийт 9 хүн томилогдон ирэх болно.

№	Томилгодох байгууллага	Томилгогдсон хугацаа	Мэргэжил
1	Сургалт Судалгаа Хөрөнгө Оруулалт Барилгын Захиалагчийн Алба	2жил	Барилгын Инженер
2	ХААИС-н харьяа Дархан-Уул аймгийн Ургамал Газар Тариалангийн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн	2жил	Чанрын хяналт
3	МУБИС, Байгалийн Ухааны Сургууль	2жил	Байгаль Шинжлэлийн Багш
4	Хавдар Судлалын Үндэсний Төв	2жил	Сувилагч
5	Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв	2жил	Компютерын Багш
6	Сэлэнгэ аймгийн 4-р Сургууль	2жил	Бага Ангийн Багш
7	Орхон аймгийн Жүдо бөхийн Холбоо	2жил	Жүдо
8	Дархан-Уул аймгийн 15-р Сургууль	2жил	Компютерын Багш
9	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв	2жил	Хөдөлгөөн Засалч



## Ёндонсампил овогтой Баярхүү, 1986 оны сургалтанд оролцогч

Энэ жилийн 3 сард гар утас руу минь Жайкагаас нэгэн дуудлага ирснээр одоогоос 25 жилийн өмнө Японд сургалтанд оролцсон үнэтэй дурсамжийг минь сэргээж өгсөн юм. Ингээд та бүхэнтэй тэр үеийнхээ дурсамж, туршлагаас хуваалцъя гэж бодлоо. Юуны түрүүнд Япон улсад очиж, үйлдвэрлэлийн дадлага хийж, тус улсын хөгжил, техникийн дэвшил, ард түмний амьдралтай танилцаж олон зүйлийг сурах боломж олгосон ЖАЙКА болон Япон улсын засгийн газарт дахин талархалаа илэрхийлье.

Намайг сургалтанд оролцохоор Япон улс руу явах тэр үед Монгол улс маань төрөл бүрийн томоохон үйлдвэрүүдтэй, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, өнөөгийн Монгол улсаас өөр улс байлаа.

Миний бие оёмол хувцасны загвар зохион бүтээлт, дэвшилтэт технологиос суралцаж, оёдлын үйлдвэрийн шинэ тоног төхөөрөмжүүдийг судлахаар тус орныг зорьсон юм. Тэр үед асар өндөр хөгжилтэй Япон улсад үйлдвэрлэлийн дадлага хийнэ гэдэг бол зүүд мэт санагдаж, явахынхаа өмнөх орой ноёр хулжиж байж билээ.

Бид Улаанбаатараас Москва хүртэл 8 цаг гаруй нисэн, Сакүра цэцэг цэцэглэж эхлэх хаврын нэгэн өдөр Наритагийн Олон Улсын Нисэх Онгоцны буудалд хүрч, тэнд биднийг ЖАЙКА-ийн ажилтан Үзүка Рио угтан авч байсан нь өнөө хэр нь тодхон санагдаж байна. Бид Юнитика компаний гадаад харилцааны ажилтан Нагиса Арасэ гуайн удирдлаган дор оёдлын олон үйлдвэрүүдтэй танилцаж, Кюүшюү арлын цамцны үйлдвэрт дадлага хийж, Япон хүмүүсийн хичээнгүй зангаас суралцан, мэргэжлийн мэдлэг чадвараас гадна хүн болж төлөвшихэд хэрэгтэй насан туршийн мэдлэг болох олон зүйлсийг эзэмшиж чадсан билээ.

Түүнчлэн, Оосака хотын Maronie Fashion Design мэргэжлийн сургуулийн оюутнуудтай сар гаруйн хугацаанд хувцас дизайн суралцсан юм. Дадлагын

дараа эх орондоо эргэн ирж, мэргэжлийн дагуу “Тахь-Ко”, “Уран шаглаа”, “Од Гоёл” гэх мэт томоохон компаниудад ажиллаж, Япон улсад сурч мэдсэн зүйлээ өдөр тутамд хэрэгжүүлж ирсэн билээ. 1988 онд “Тахь-Ко” компани нь хувцасны эсгүүрийн размераас размерт шилжүүлдэг CAD системийн компьютерийг Япон улсын JUKI компаниас худалдан авч суурилуулахад миний бие томоохон үүрэг гүйцэтгэсэн гэж болно.



1986 он Сургалтанд оролцож байх үеийн зураг

Монгол улс төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн өнөө үед, миний бие багахан оёдлын үйлдвэр байгуулан ажиллаж ирлээ. Манай үйлдвэрийн ойролцоо “Шинэ Монгол” гэдэг сургууль байрладаг юм. Манай үйлдвэр тэрхүү сургуулийн дүрэмт хувцсыг оёдог бөгөөд энэ бүх үйл ажиллагаанд Япон улсад сурч мэдсэн зүйл маань байнга хэрэг болж байдагт ямагт баярлаж явдаг билээ.

2011 оны 3 сарын 11-нд Япон улсад тохиолдсон Цүнами болон байгалийн гамшигт үзэгдэлд олон хүний амь нас эрсдэж, эд материалаар асар их хохирсон явдалд гүнээ харамсаж байна. Ингээд Японы ард түмнээс сурсан мэдсэн зүйлийнхээ ачийг бага боловч хариулахаар энэ жил “Шинэ Монгол” сургуулийг төгсч буй охин Дэлгэрийн хамтаар дулаан хөнжил оёж, “Шинэ Монгол” сургуулийн захирал Галбадрахаар дамжуулан Японы ард түмэнд хүргүүлсэн билээ.

Япон улсын хөгжил дэвшилээс олон зүйлийг сурч, сурсан зүйлээ ажил хэрэг болгон эх орныхоо хөгжил дэвшилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах боломж олгосон ЖАЙКА болон Япон улсын Засгийн газар, Японы ард түмэнд маш их баярлаж явдагаа илэрхийлэхэд таатай байна.